

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРОО

ТАНИЛЦУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 01

Улаанбаатар хот

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлттэй танилцан хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэлээ.

Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 3 зорилтын 50 арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Үүнд:

(Хүснэгт-1)

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт гээлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Биеийн тамирын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангана.							
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1.1. Биеийн тамир, спортын үйлчилгээг өргөжүүлж, биеийн тамир, спортыг хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг болгох таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.							
	Улсын төсөв: 10,000.0	Оролцогчдын тоо	3000	3100	Иргэдийн дунд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын дадал хэвшлийг дэмжин, спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ажилтан албан хаагчид, хороодын ажилтан албан хаагч, иргэдийн		100%

1.1.1.	Нийслэл, дүүргээс зохион байгуулдаг "Өвлийн өдөрлөг" арга хэмжээнд оролцох, үйл ажиллагааг зохион байгуулна.					дунд өвлийн өдөрлөг арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 16-21 -ны өдөр Хандгайт дахь Батлан хамгаалах яамны харьяа зуслангийн газарт цасны бүжиг, гийр өргөлт, корнхол төрлүүдээр зохион байгуулж 117 байгууллагын 3,069 иргэнийг хамруулсан. Мөн "Монгол нүүдэлчин" өвлийн фестивалийн хүрээнд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 2025 оны 02 дугаар сарын 16-наас 22-ны өдрүүдэд иргэдийн дунд мөсний шагай, мөсний сур, корнхолл төрлүүдээр арга хэмжээ зохион байгуулж 15 байгууллагын 320 иргэн оролцлоо.				
1.1.2.	Цэцэрлэгийн хүүхдүүдийн "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн арга хэмжээг зохион байгуулна.	Улсын төсөв: 5,000.0	Оролцогчдын тоо	300	330	2025 оны Дүүргийн аварга шалгаруулах "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн арга хэмжээг оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Спортын төв ордны зааланд амжилттай зохион байгуулж 12 сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 360 хүүхэд оролцлоо.				100%
1.1.3.	ЕБС-ийн сурагчдын "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн арга хэмжээг зохион байгуулна.	Улсын төсөв: 4,000.0	Оролцогчдын тоо	200	220	2025 онд Байгууллагын биеийн тамирын арга хэмжээний төсвийг төсвийн дээд шатны байгууллагаас татсан тул дүүргийн аварга шалгаруулах "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн арга хэмжээг зохион байгуулах боломжгүй болсон тул арга хэмжээ явагдаагүй.				30%
1.1.4.	ЕБС-ийн сурагчдын "Хөгжөөн дэмжигчид"-ийн арга хэмжээг зохион байгуулна.	Улсын төсөв: 5,000.0	Оролцогчдын тоо	110	130	2025 оны Дүүргийн аварга шалгаруулах "Хөгжөөн дэмжигчид"-ийн арга хэмжээг 04 дүгээр сарын 01-ний өдөр Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоотой хамтран Спортын төв ордны зааланд амжилттай зохион байгуулж 12 сургуулийн 18 багийн 288 сурагчид оролцлоо.				100%
1.1.5.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхдүүдэд зориулсан биеийн тамир, спортын арга хэмжээг	Улсын төсөв: 12,000.0	Оролцогчдын тоо	300	310	2025 оны Дүүргийн аварга шалгаруулах Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын 5 төрөлт арга хэмжээг 05 дугаар сарын 25-ны өдөр 15-ын талбайд зохион байгуулж 30 хорооны 260 иргэн				100%

	зохион байгуулна.		Улсын төсөв: 4,000.0	Оролцогчдын тоо	30	35	идэвхтэй хамрагдлаа.	
1.1.6.	СӨББ-ын арга зүйч, багш нарын дунд эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулна.						2025 онд Байгууллагын биеийн тамирын арга хэмжээний төсвийг төсвийн дээд шатны байгууллагаас татсан тул СӨББ-ын багш, арга зүйчдийн эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулах боломжгүй болсон тул арга хэмжээ явагдаагүй.	30%
1.1.7.	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагын ажилтан, албан хаагч, багш нарын дунд сургалт зохион байгуулна.		Улсын төсөв: 8,000.0	Сургалтын тоо	2	3	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Ерөнхий боловсролын сургуулийн арга зүйч, багш, эмч нарын дунд Бие бялдрын хөгжилт чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын онол, практик хосолсон нийт 3 удаагийн сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 28, 30-ны өдрүүдэд зохион байгуулж 150 албан хаагчдыг хамрууллаа.	100%
1.1.8.	Цэцэрлэгийн хүүхдүүдийн 100-н буудалт даамны арга хэмжээг зохион байгуулна.		Улсын төсөв: 2,000.0	Оролцогчдын тоо	90	100	Баянзүрх дүүргийн 60 жилийн ойг тохиолдуулан Цэцэрлэгийн хүүхдүүдийн "100 буудалт даам"-ны дүүргийн аварга шалгаруулах арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 12-13-ны өдөр 5-6 насны төрөлд уламжлал болгон зохион байгуулж дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн 43 цэцэрлэгийн 130 тамирчид оролцлоо.	100%
1.1.9.	"Ажил танилцуулах" өдөрлөг, бүх нийтийн арга хэмжээг зохион байгуулна.		Улсын төсөв: 10,000.0	Оролцогчдын тоо	350	500	"Автомашингүй өдөр" нэгдсэн арга хэмжээ 2025 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү нээлттэй өдөрлөгт Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хорооны ажилтан, албан хаагчид иргэдийн спортоор хичээллэх сонирхлыг нэмэгдүүлэх, ганцаарчилсан спортын төрлийн үйл ажиллагааг таниулах, сурталчлах, мөн байгууллагын үйл ажиллагааг танилцуулах ажил, арга хэмжээг зохион байгуулах талбайд амжилттай зохион байгуулж даргс, шатар, даамны төрлүүдээр нээлттэй чөлөөт тоглолт явуулж 210 иргэнийг	100%

							хамрууллаа. Өдөрлөгийн үеэр иргэдэд өдөр тутам хийж хэвших дасгал, эмнэлгийн анхны тусламж, дасгал хөдөлгөөний ач холбогдол, биеийн жингийн индексийг тодорхойлох зөвлөмж, дасгал хөдөлгөөнөөр эрүүлж, бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын зөвлөмж, эрүүл бие-эрүүл амьдрал гэх мэт 12 нэр төрлийн 200 ширхэг гарын авлага, боршурыг хэвлэн тарааж, зөвлөмж өгч ажиллалаа. Мөн Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хорооны асарт явуулж байгаа үйл ажиллагаанд оролцсон иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг QR код уншуулан авч ажиллалаа.					
Зорилт 1.2. Төр хувийн хэвшлийн түншлэлд суурилсан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгож, иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.												
1.2.1.	Биеийн тамир, спортын хамтлагийн тоог нэмэгдүүлж үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	-	Хамтлагийн тоо	80	83	Биеийн тамир, спортын үйл ажиллагаанд байгууллагынхаа албан хаагчдыг татан оролцуулах, биеийн тамир, спортын үйлчилгээг хүргэх, хамтлагийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, харьяа хэлтэс албанд биеийн тамир, спортын хамтлагийг байгуулан тогтмолжуулан ажиллах талаар зөвлөн туслах, мэдээ мэдээллээр хангах, үйл ажиллагааг тогтмол явуулж байна. 2025 онд 3 хамтлаг шинээр байгуулагдаж 84 хамтлаг үйл ажиллагаагаа явуулж байна.	100%					
1.2.2.	Иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээг чанаржуулах зорилгоор магадлан итгэмжлэлийн болзол хангасан спортын клубын тоог нэмэгдүүлнэ.	-	Болзол хангасан спортын клубын тоо	3	4	Баянзүрх дүүрэгт спортын 3 клуб магадлан итгэмжлэгдсэн байна. Одоогоор улсын хэмжээнд магадлан итгэмжлэлд хамруулах ажил явагдаагүй байна.	70%					

1.2.3.	Дүүргийн хэмжээнд "Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил" авч, программд шивж оруулна.	Улсын төсөв: 10,000.0	Сорилд хамрагдагчдын н тоо	20000	20050	2025 оны хагас жилийн байдлаар "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах тухай" захирамж гарган Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо, Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв хамтран сорил авах ажлын хэсэг байгуулан 2025 оны 04 дүгээр сарын 07-оос 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл зохион байгуулж 26 хэлтэс албадын 1200 ажилтан албан хаагч, 5890 иргэн бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан. Жилийн эцсийн байдлаар сорилыг 10-сарын 01-ээс 11 сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд дүүргийн хэмжээнд зохион байгуулж 13,578 иргэдийн сорилыг авч нэгтгэн дүн мэдээг ЗГХА-Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлж ажиллалаа.	100%
1.2.4.	"Улаанбаатар Марафон-2025" арга хэмжээг дүүрэгт зохион байгуулж, оролцуулна.	Улсын төсөв: 3,000.0	Оролцогчдын тоо	2100	2110	Сорилд хамрагдсан иргэдийн дунд А үнэлгээтэй 4427, В үнэлгээтэй 3999, С үнэлгээтэй 3536, D үнэлгээтэй 1177, F үнэлгээтэй 439 иргэн байна.	100%

						2025 цом аялах аяныг зохион байгуулж байгууллагууд 119 арга хэмжээ зохион байгуулж 10,987 албан хаагчдыг хамруулан ажиллалаа.				2025 онд Байгууллагын биеийн тамирын арга хэмжээний төсвийг төсвийн дээд шатны байгууллагаас татсан тул Иргэдийн спортын XIII наадмыг дүүрэгт зохион байгуулах боломжгүй болсон тул арга хэмжээ явагдаагүй.	30%	
1.2.5.	Иргэдийн спортын XIII наадмыг дүүрэгт зохион байгуулж, шигшээ тэмцээнд баг тамирчдыг оролцуулна.	Орон нутгийн төсөв: 85,000.0	Оролцогчдын тоо	2300	2310					Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг" волейболын тэмцээн 2024 оны 11 дүгээр сарын 23-24-ны хооронд Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 14, 155, 48, 53, 69 дүгээр сургуулиудын спорт зааланд хоёр насны ангиллаар амжилттай зохион байгуулагдаж ахлах, дунд ангилалд 37 сургуулийн 126 багийн 1651 тамирчин оролцлоо.	100%	
1.2.6.	ЕБС-ийн сурагчдын бөмбөг, Сагсан Волейболын "Улаанбаатар лиг" фестивалыг зохион байгуулна.	Улсын төсөв: 25,000.0	Оролцогчдын тоо	2600	2650					Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн тэмцээн 2025 оны 01 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 33, 48 дугаар сургуулиудын спорт зааланд бага, дунд, ахлах насны ангиллаар амжилттай зохион байгуулж 99 багийн 1170 тамирчин оролцлоо.		
1.2.7.	ЗДТГ-ын харьяа хэлтэс албад, ЕБС, СӨББ-ын удирдлага болон ажилтан албан хаагчдын биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулна.	Улсын төсөв: 20,000.0	Оролцогчдын тоо	2300	2500					Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хороо, Боловсролын хэлтэстэй хамтран Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын багш ажилтан, албан хаагчдын дундах спортын 5 төрөлт арга хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд Төрийн өмчийн 55 цэцэрлэгийн 1100 ажилтан, албан хаагч хурд, хүч, авхаалж самбаа, ур чадвараа сорин оролцлоо.	100%	

						Засаг даргын нэрэмжит харьяа хэлтэс албадын спортын 5 төрөлт арга хэмжээ 2025 оны 02 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж 41 хэлтэс албадын 26 багийн 1,014 гаруй ажилтан албан хаагчид оролцлоо.	
1.2.8.	Дүүргийн хэмжээнд Биеийн тамирын дасгал хөдөлгөөн болон бусад спортын төрлөөр дүүргийн иргэдэд үйлчилгээ үзүүлж, нийтийг хамарсан ("Алхацгаая-гүйцгээе", "Эерэг хандлага-Эрүүл нийгэм" гэх мэт) томоохон арга хэмжээг зохион байгуулна.	Улсын төсөв: 20,000.0	Оролцогчдын тоо	5000	5100	2025 оны хагас жилийн байдлаар Соёл, аялал жуулчлал, спортын арга хэмжээний нэгдсэн цаглаврын хүрээнд Соёлын биет бус өвийн төрөл зүйлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор "МОНГОЛ НҮҮДЭЛЧИН" өвлийн фестиваль "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн"-д 2025 оны 02 дугаар сарын 16-наас 22-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. "Монгол" нүүдэлчин өвлийн фестивалийн хүрээнд Мөсний сурын харвааны тухай ойлголт, сурын харвааны онцлог түүхэн уламжлал мөн Корнхолын спортыг сурталчлан таниулах зорилгоор Ерөнхий боловсролын 5 сургууль (84, 111, Пугонхуа, 133, 157)-ийн 200 орчим ахлах ангийн сурагчдад тайлбарлан таниулж, тэмцээн зохион байгууллаа. Мөн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд ахмадын дунд чөлөөт алхалт, "Фестиваль"-ийн тойрон аялал, мөсөн шагайн харваа, мөсөн сурын төрлүүдээр арга хэмжээ зохион байгуулж 90 ахмад иргэн идэвхтэй хамрууллаа. 3 дугаар улирлын байдлаар Хөгжье, эрүүлжье-хөдөлгөөн хийе арга хэмжээг 05 дугаар сарын 12-ны өдөр Баянзүрх дүүргийн 7 дугаар хороо Хөл бөмбөгийн задгай талбайд зохион байгуулж Ерөнхий боловсролын сургуулийн 300 өсвөр насны сурагч хүүхдүүд, тэдний эцэг, эх, асран хамгаалагчид хамрагдлаа. 4 дүгээр улирлын байдлаар Баянзүрх дүүргийн 43 хороо явган алхалтын клуб байгуулах ажидыг зохион байгуулж сар бүр 2 удаагийн алхалтыг	100%

							тогтмол хорооны иргэдийн дунд зохион байгуулж давхардсан тоогоор 43 хорооны 2500 иргэнийг хамруулан ажиллалаа.	
							Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зарлиг “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрийг, хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголчуудын өв соёл, язгуур урлаг, өвөрмөц уламжлалыг шингээсэн “Амар байна уу” Монгол бүжгийн дасгалыг хүүхэд, залуучуудад сурталчлан таниулах, хэвшүүлэх, идэвхтэй хөдөлгөөнд өргөнөөр татан оролцуулах, идэвх сонирхлыг өрнүүлэх, бие даан хичээллэх эрмэлзлийг төрүүлэх зорилгоор Биеийн тамир, спортын хороо, Uugee's Dance бүжгийн спортын клубтэй хамтран Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд амар байна уу арга хэмжээг 2025 онд чэллэнж байдлаар зохион байгуулж 4 дүгээр улирлын байдлаар 1400 сурагчдыг хамруулан ажиллалаа. Мөн Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын багш, сурагчид, дүүргийн эрүүл мэндийн төвийн харьяа хороодын Өрхийн эрүүл мэндийн төвийн албан хаагчдын дунд ажлын байрны дасгал болон завсарлагааны үеийн дасгалыг 2025 оны 11 сард чэллэнж байдлаар зохион байгуулж 4 сургуулийн 500 ажилтан албан хаагч, сурагчдыг хамрууллаа.	100%
Зорилт 1.3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.								
1.3.1.	Арга хэмжээний үеэр “Эрүүл зөв амьдрах дадал, хэвшил, дасгал хөдөлгөөнийг сурталчлах” зөвлөмж, гарын авлага гарган боловсруулж, иргэдэд тараах үйл ажиллагааг зохион	Улсын төсөв: 2,000.0	Гарын авлагын төрөл	22	23		Дүүргийн нийтийг хамарсан томоохон арга хэмжээ, спортын уралдаан тэмцээний үйл ажиллагаанд эрүүл амьдралын хэв маяг, эрүүл хооллолт, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх гэх мэт 25 нэр төрлийн 5000 гарын авлагыг иргэдэд тараан ажиллалаа.	100%

	байгуулна.								
1.3.2.	Зохион байгуулсан арга хэмжээний протокол, материал, хөтөлж, тайлан баримтжуулах, боловсруулан, мэдээг холбогдох байгууллагад хүргүүлнэ.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	22	23	2025 оны жилийн эцсийн байдлаар 3 арга хэмжээний захирамжийн төслийг батлуулж мөн биеийн тамирын арга хэмжээний 16 тайлан, мэдээг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.	100%		
1.3.3.	Үйл ажиллагаатай холбогдох судалгааг гаргах, нэгтгэн дүгнэнэ.	-	Судалгааны тоо	2	3	2025 оны байдлаар "Автомашингүй едөр" нэгдсэн арга хэмжээ 2025 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү нээлттэй өдөрлөгт Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй танилцуулж, иргэдийн спортоор хичээллэх сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор 3 арга хэмжээ явуулж мөн дасгал хөдөлгөөний ач холбогдолын талаар гарын авлагыг тарааж ажилласан бөгөөд энэхүү арга хэмжээнд оролцсон иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг QR код уншуулан 150 иргэнээс авч ажиллалаа.	100%		
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангана.									
Зорилт 2.1. Орчин үеийн шаардлага, олон улсын жишиг, иргэдийн эрэлт хэрэгцээ, үндэсний онцлогт нийцсэн биеийн тамир, спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх, дүүрэгт үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын залгамж халааг бэлтгэх, тэмцээн уралдаанд оролцож амжилтаа ахиулах таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.		Улсын төсөв: 30,000.0 Орон нутгийн төсөв: 553,185.0	Сургалт дасгалжуулагчдын ахиц гарч тамирчдын ур чадвар, амжилт ахина.	Нийслэл болон дүүргийн спортын арга хэмжээнд 5641 иргэн оролцдог, 13 төрлөөр дүүргийн	Спортын тэмцээн уралдааны зохионы байгуулалт сайжирч төрийн бус байгуул агуудын оролцоо нэмэгдэн тамирчд	Дүүрэгт биеийн тамир, спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх, үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлэх зорилгоор спортын холбоод, клубүүдтэй хамтран ажиллах, ажил гүйцэтгэх гэрээ байгуулж (Монголын сагсан бөмбөгийн холбоо, Монголын волейболын холбоо, Хөлөгт тоглоом клуб) өсвөр үе, залуучуудын дундах тэмцээнийг спортын 22 (гүйлтийн тэшүүр, шорт треjk, 100 буудалт даам, самбо бөх, чөлөөт бөх, волейбол, сагсан бөмбөг, жү-до бөх, бокс, шатар, хүндийн өргөлт, жюу жицү, таеквондо, хөлбөмбөг, ширээний теннис, хөнгөн атлетик, усанд сэлэлт) төрлөөр зохион байгуулж давхардсан тоогоор 473 байгууллагын 5615	100%		

		аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулсан, спортын 14 төрлөөр өсвөрийн шигшээ багтай, МХСН, МБАТС Н-дад тогтмол эхний байр эзэлж байна.	ын амжилт ахиж спортын болон наадмуудад үзүүлсэн амжилт ахисан байна.	тамирчин оролцсон. Өсвөр үеийн тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх зорилгоор дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг спортын 14 төрлөөр нийт 1000 гаруй тамирчин хүүхэд хичээллэж байгаа бөгөөд үүнээс 234 тамирчин Дүүргийн аварга шалгаруулах тэмцээн болон бусад шатны уралдаан тэмцээнээс сонгон шалгаруулж бүртгэн авч хичээллүүлж байна.	
2.1.1.	Сар, улирал, жилийн тайлан мэдээг холбогдох нэгж, байгууллагад хугацаанд нь хүргүүлнэ.	Тайлан, мэдээний хугацаагаар	Сар бүр	2025 оны жилийн эцсийн байдлаар спортын уралдаан тэмцээний тайлан, мэдээг улирал бүр гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.	100%
	"Монголын хүүхдийн спортын VIII наадам", "Монголын бүх ард түмний XVI наадам"-ын анхан шатны тэмцээнийг зохион байгуулан шалгарсан тамирчдыг шигшээ тэмцээнд	Зохион байгуулах спортын төрлийн тоо	48	48	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам" -ын хүрээнд Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадмыг 2025 оны 02 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд, зуны наадмыг 05 дугаар сарын 26-наас 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулагдахаар нэгдсэн заавар батлагдсан.

2.1.2.	оролцуулна.	Орон нутгийн төсөв: 182,900.0	Монголын хүүхдийн спортын өвлийн спортын VIII наадмын гүйлтийн тэшүүр, шорт трейкийн Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Улаанбаатар хотын Хандгайт дахь стандартын мөсөн гулгуурын 400 м-н талбайд, шорт трейкийн 111 м-н стандартын талбайд Монголын тэшүүрийн холбоотой хамтран олон улсын дүрмийн дагуу амжилттай зохион байгуулж 6 байгууллагын 50 тамирчин 6 насны ангиллаар хурд хүчээ сорин өрсөлдөж аваргуудаа тодрууллаа. Монголын хүүхдийн өвлийн спортын VIII наадмын шигшээ тэмцээн Улаанбаатар хот, Орхон аймагт "Мөрөөдлийнхөө төлөө-Шударга өрсөлдөө" уриан дор 2025 оны 02 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд 8 спортын 80 зай, ангилалд 22 багийн нийт 546 тамирчин 478 багц медалийн төлөө өрсөлдөж Нийслэлийн 9 дүүргээс Баянзүрх дүүргийн баг 8 алт, 4 мөнгө, 5 хүрэл нийт 17 медальтайгаар Тэргүүн байр эзэлсэн амжилттай оролцлоо. "Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмыг дүүрэгт зохион байгуулж шигшээ тэмцээнд оролцуулах тухай" Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/285 дугаар захирамжийн хүрээнд спортын 16 төрлөөр анхан шат буюу дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж давхардсан тоогоор 279 байгууллагын 2046 тамирчин оролцлоо. Монголын хүүхдийн спортын VIII наадамд Баянзүрх дүүргийн өсвөрийн шигшээ баг тамирчид спортын 23 төрөлд 275 тамирчин, 30 багш, дасгалжуулагч, 10 албаны ажилтны бүрэлдэхүүнтэй оролцож 12 алт, 23 мөнгө, 22 хүрэл нийт 57 медаль хүртэж нийлбэр дүнгээр улсын хэмжээнд 7 дугаар байр, нийслэлийн хэмжээнд 5-р байранд жагссан амжилттай
--------	-------------	--	--

100%

						оролцлоо.	Дөрвөн жилд нэг удаа үндэсний хэмжээнд зохион байгуулагддаг 64 жилийн түүхтэй Монголын бүх ард түмний спортын зуны XVI их наадам анх удаа орон нутагт буюу Баянхонгор аймагт, спортын зарим төрлүүд Улаанбаатар хотод 2025 оны 09 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд зохион байгуулагдлаа. Наадмын шигшээ тэмцээнд, улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүргийн 291 дасгалжуулагчийн удирдлага дор нийт 3400 тамирчин 879 багц медалийн төлөө Баянхонгор аймагт спортын 17 төрөл, Улаанбаатар хотод спортын 11 төрлөөр өрсөлдөж хурд, хүч, авхаалж самбаа сорин өрсөлдсөнөөс Баянзүрх дүүргийн баг тамирчид 34 алт, 24 мөнгө, 22 хүрэл медаль хүртэж МБАТС-ын XVI наадмын Тэргүүн байрыг эзэлсэн өндөр амжилт үзүүлж амжилттай оролцлоо.	
2.1.3.	Өсвөр үеийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 23 төрлөөр зохион байгуулна. /шинээр хөгжиж буй 1 спортын төрлийг дэмжин ажиллах/	Улсын төсөв: 10,000.0 Орон нутгийн төсөв: 72,050.0	Оролцогчдын тоо	1980	2100	Дүүргийн өсвөр үеийнхний дунд спортыг түгээн дэлгэрүүлэх, улсын аварга шалгаруулах тэмцээн оролцох тамирчдыг сонгон шалгаруулах зорилгоор дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 16 төрлөөр зохион байгуулж нийт давхардсан тоогоор 279 байгууллагын 2046 тамирчин сурагчид оролцсон.	100%	
2.1.4.	Залуучуудын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 3 төрлөөр зохион байгуулна.	Улсын төсөв: 3,000.0	Оролцогчдын тоо	150	200	Баянзүрх дүүргийн залуучуудын 100-н буудалт даамны дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 09-ний өдөр 87 дугаар сургууль дээр зохион байгуулж 10 байгууллагын 42 тамирчин оролцлоо.	100%	

2.1.5.	Насанд дүүргийн шалгаруулах спортын 20 төрлөөр зохион байгуулна.	Улсын төсөв: 7,000.0 Орон нутгийн төсөв: 75,235.0		Оролцогчдын тоо	86	300	Нийслэлийн Баянзүрх дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн боловсролын байгууллагын удирдлага, багш нарын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Боловсрол кап-2025" спортын 7 төрөлт Үндэсний бөх, Шатар, Ширээний теннис, Дартс, Шугаман бүжиг, Волейбол, Сагсан бөмбөг/ тэмцээнийг 2025 оны 11 дүгээр сарын 15-29-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж Ерөнхий боловсролын 43 сургууль, 40 цэцэрлэгийн нэгдсэн 2 баг, хувийн хэвшлийн 8 сургууль нийт 83 байгууллагын 215 багийн 1,894 удирдлага, багш, тамирчид оролцлоо.	100%
2.1.6.	Ахмадын аварга шалгаруулах тэмцээнийг 1 төрлөөр зохион байгуулна.	Улсын төсөв: 3,000.0		Оролцогчдын тоо	100	150	Соёл, аялал жуулчлал, спортын арга хэмжээний нэгдсэн цаглаварын хүрээнд Соёлын биет бус өвийн төрөл зүйлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилготой "МОНГОЛ НҮҮДЭЛЧИН" өвлийн фестиваль "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн"-д 2025 оны 02 дугаар сарын 16-наас 22-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. "Монгол" нүүдэлчин өвлийн фестивалийн хүрээнд Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хороо, ахмадын хороотой хамтран 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хороодын ахмадын дунд чөлөөт алхалт, "Фестиваль"-ийн тойрон аялал, мөсөн шагайн харваа гэсэн төрлүүдээр арга хэмжээ зохион байгуулж 60 ахмад иргэн оролцлоо.	100%
	Хот, улсын аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдыг бэлтгэн оролцуулах, дэмжлэг	Улсын төсөв:		Оролцогчдын тоо	200	210	Баянзүрх дүүргээ төлөөлөн улсын аварга шалгаруулах тэмцээнд Самбо бөх, Тэшүүр, Хүндийн өргөлтийн төрлөөр өсвөрийн 50 тамирчин оролцож, 57 медаль, Хотын аварга	

2.1.7.	үзүүлнэ.	5,000.0 Орон нутгийн төсөв: 5,000.0				шалгаруулах тэмцээнд сагсан бөмбөг, 100-н буудалт даам, Жудо бөхийн төрлөөр 230 тамирчин оролцож 26 медаль тус тус хүртсэн амжилттай оролцсон.	100%
2.1.8.	Дасгалжуулагч, биеийн тамирын багш нарт сургалт, семинар зохион байгуулна.	Улсын төсөв: 2,000.0 Орон нутгийн төсөв: 3,000.0	Зохион байгуулсан сургалт, семинарын тоогоор	1	2	Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмыг дүүрэгт зохион байгуулах ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн биеийн тамирын багш, дасгалжуулагчдын дунд хүүхдийн спортын наадамд тамирчдыг бэлтгэн оролцуулах, хүүхдийн наадмын ерөнхий удирдамжыг танилцуулах зорилготой сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр 48-р сургуулийн Урлагын зааланд зохион байгуулж 15 сургуулийн 25 багш, дасгалжуулагч хамрагдаж мэдээлэл, сургалт, зөвлөгөө авч хамтран ажиллалаа.	100%
2.1.9.	Тэмцээн уралдааны заавар удирдамж гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэх, зохион байгуулсан тэмцээн уралдааны протокол, материал, хөтөлж, баримтжуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	48	48	2025 оны жилийн эцсийн байдлаар спортын уралдаан тэмцээний 22 удирдамж, зааврыг боловсруулан батлуулж, мөн холбогдох тайлан, мэдээг гарган баримтжуулж холбогдох газар хүргүүлэн ажиллалаа.	100%
2.1.10.	Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийг удирдлагаар хангах, багийн тамирчдыг сэргэлтийн бэлтгэл сургуулилтад хамруулна.	Орон нутгийн төсөв: 212,500.0	Бэлтгэлд хамруулсан спортын төргийн тоо	2	3	Дүүргийн засаг даргад сэргэлтийн бэлтгэлд хамруулах захирамжийн төслийг өргөн барисан бөгөөд Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг сэргэлтийн бэлтгэлд хамруулах төсөв батлагдаагүй. Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийг удирдлагаар хангах, тэмцээн уралдаанд оролцох зардлыг дүүргийн орон нутгийн төсвөөс шийдвэрлэлээ.	100%

2.1.11.	Дүүргийн шигшээ багуудын дунд спортын 1 төрлөөр багийн тэмцээн зохион байгуулна.	Орон нутгийн төсөв: 2,500.0	Оролцсон багийн тоо	9	9	2025 онд Байгууллагын спортын тэмцээн уралдааны төсвийг төсвийн дээд шатны байгууллагаас татсан тул Дүүргийн шигшээ багуудын дундах тэмцээн зохион байгуулах боломжгүй болсон тул тэмцээн явагдаагүй.	30%
2.1.12.	Үйл ажиллагаатай холбогдох судалгааг гаргах, нэгтгэх, дүгнэх	Улсын төсөв: 2,000.0	Судалгааны тоо	4	5	"Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам"-ын хүрээнд 2019-2025 онуудад зохион байгуулагдсан наадмуудын шигшээ тэмцээнд оролцогчдын судалгааг нэгтгэн ЗГТА-БТСУХ-ны info@sport.gov.mn мэйл хаягаар хүргүүлэн ажиллалаа.	100%
Зорилго 3. Төрийн байгууллагын чиг үүргийг хангана.							
Зорилт 3.1. Төрийн байгууллагын нийтлэг чиг үүргийг ханган ажиллана.							
3.1.1.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, биелэлтийг тайлагнах, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, үйл ажиллагаатай холбогдон гаргах тайлан, мэдээг нэгтгэн гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллана.	-	Тайлан, мэдээний хугацаагаар	Улирал бүр	Сар бүр	Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хороо нь бодлогын баримт бичиг, төрийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд тусгагдсан үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ Биеийн тамир, спортын тухай хуулийг бүхэлд нь хэрэгжүүлж 2025 онд хэрэгжүүлэх 3 зорилт 50 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөг батлан гүйцэтгэл 94,39 хувьтай хэрэгжлээ. Мөн Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, холбогдох тайлан мэдээг улирал бүр дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллалаа.	100%
3.1.2.		-	Нэгтгэсэн мэдээний тоо	5	5	Биеийн тамир, спортын тухай статистикийн дүн мэдээг жилд нэг удаа ЗГТА-Биеийн тамир, спортын улсын хорооноос авдаг энэ ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хорооноос 2024 оны статистик мэдээ, бүртгэлийг ЗГТА-БТСУХ-оос гаргасан 5 маягтын дагуу (Биеийн тамир, спортын төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээ, шинээр	100%

	Биеийн тамир, спортын тухай статистик судалгааны дүн мэдээг нэгтгэн цахим программд оруулна.					ашиглалтад орсон барилга, байгууламжийн мэдээ, байгууллагын ажилчдын мэдээ, цолтой тамирчид, шүүгчдийн мэдээ, бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдагчдын мэдээ, спортын тамирчдын тоо, зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдагчдын тоо) гарган ЗГТА-БТСУХ-нд хүргүүлж ажилаллаа.	
3.1.3.	Ажилтан, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хангаж ажиллана.	Улсын төсөв: 2,000.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Байгууллагын "Хүний нөөцийн хөтөлбөр 2022-2025"-ын хүрээнд төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Байгууллагын ажилтан албан хаагч мэдлэг ур чадвараа дээшлүүлэхээр дотоод, гадаадын 18 сургалтад хамрагдаж холбогдох тайланг хүргүүлэн ажиллалаа.	100%
3.1.4.	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнана.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	Байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа хууль дүрмийн дагуу явагдаж байгаа ба гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнан ажиллалаа.	100%
3.1.5.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу үйл ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлж ажиллана.	-	Байршуулсан мэдээллийн тоо	316	326	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Баянзүрх дүүргийн биеийн тамир, спорт хорооны фэйсбүүк пэйж хуудас, цахим сайтад 657 спортын уралдаан тэмцээн, биеийн тамирын арга хэмжээний мэдээ болон бусад мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь байршуулан нийтлэж 13,247 лайк, 3,356 удаа хуваалцаж, 2,571,357 хандалт авч Биеийн тамир спортын хорооноос зохион байгуулсан арга хэмжээ, уралдаан тэмцээн, байгууллагын даргаар батлагдсан удирдамж, заавар, холбогдох мэдээ мэдээллийг вэб сайтад тухай бүр ил тод, нээлттэй байршуулсан ба иргэд, аж ахуй нэгж, албан байгууллагууд болон хороод мэдээллээ бүрэн авч	100%

						хамтран ажиллаж байна. Мөн фэйсбүүк хуудсыг пэйж хуудас болгон хөгжүүлснээр мэдээ, мэдээллийг түгээх хурд, хандалт өнгөрсөн онтой харьцуулахад 2,492 дагаачаар нэмэгдсэн үзүүлэлт гарсан.	
3.1.6.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаанд шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	2	4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөө гарган батлуулж, түүний дагуу 4-р улирлын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн ажиллалаа.	100%
3.1.7.	Даргын дэргэдэх удирдлагын зөвлөл, Ёс зүйн хороо, дотоод хяналтын зөвлөл, өмч хамгаалах зөвлөл, эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, дотоод хяналт тавьж ажиллана.	-	Дотоод хяналт шалгалт хийсэн ажлын тоо	2	2	Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулах нийтлэг журам"-ын биелэлтийг хангах ажлын хүрээнд Дотоод хяналт шалгалтын комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, төлөвлөгөө гарган байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг шинэ хууль, журмын дагуу шинэчлэн батлуулж, дүгнэх ажлыг хийж, байгууллагын дэргэдэх зөвлөл, комиссуудын жилийн ажлын төлөвлөгөөг гаргуулан батлуулж 1-4 дүгээр улирлын гүйцэтгэлийг тайланг хянах ажлуудыг гүйцэтгэн ажиллалаа.	100%
3.1.8.	Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмыг шаардлагын дагуу хангаж ажиллана.	-	Хэрэгжүүлсэн чиг үүргийн тоо	4	4	2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга хадгалах 38, 70 жил хадгалах 9, түр хадгалах 27, нийт 74 баримтуудыг хүлээн авч, бүртгэн авсан.	100%

3.1.9.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлын зохион байгуулалтад оролцоно.	-	Зохион байгуулалтад оролцсон ажлын тоо	2	3	Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар үндэсний хэмжээнд өрнөж буй “Тэрбум мод” хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах, мод тарих соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Биеийн тамир, спортын хорооны ажилтан, албан хаагчид 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Баянзүрх дүүргийн 28 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших “Олон улсын Эко цэцэрлэгт хүрээлэн”-д Баянзүрх дүүргийн Засаг даргын “Мод тарих үндэсний өдөр”-ийг зохион байгуулах тухай 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/695 дугаар захирамжийг үндэслэн мод тарих өдөрлөг арга хэмжээнд Хайлаас (50 ширхэг)-г мэргэжлийн диндрологичдын зааварчилгаа, хяналт дор төгөл үүсгэн тарилаа.	100%
3.1.10.	Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем дэх edoc.ulaanbaatar.mn системийн ашиглалтыг хангаж, албан бичгийн шийдвэрлэлтийг хангаж ажиллана.	-	Албан бичгийн шийдвэрлэлтийн хувь	100	100	2025 оны 11 дүгээр сарын 28-ны байдлаар албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн https://edoc.ulaanbaatar.mn систем буюу цахим хаягаар ирсэн албан бичиг -146, үүнээс хариутай 25 байгаагаас шийдвэрлэлт – 100 хувьтай, 103 албан бичгийг давхардсан тоогоор 1200 албан байгууллага, аж ахуйн нэгжид явуулсан байна. Ирсэн бичгийн шийдвэрлэлт-100 хувь, Хариутай бичгийн шийдвэрлэлт-100 хувь, Явуулсан бичгийн шийдвэрлэлт-100 хувьтай байна.	100%
3.1.11.	Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн программ (ep.ulaanbaatar.mn)-ын дэд системүүдийг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглана.	-	Ашигласан дэд системийн тоо	10	11	Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн программ (ep.ulaanbaatar.mn)-ын дэд системүүдийг өдөр тутмын үйл ажиллагаандаа 12 дэд системийг тогтмол ашигладаг.	100%

3.1.12.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний мэдээг төрийг албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системд оруулна.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	2025 он гарсаар ажилтны шилжилт хөдөлгөөн 4 бүртгэгдсэн бөгөөд шийдвэрлэж ажилласан.	100%
3.1.13.	Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг тайлагнах, ХАСХОМ гаргах албан хаагчдыг хуулийн хугацаанд мэдүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	Авлигын эсрэг 2025 оны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцийг соёрхон батлах тухай хууль, Авлигын эсрэг хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270-р зүйлийг тус тус анхааруулах, сануулах, соён гэгээрүүлэх зорилготой ухуулах сурталчилгааг сайт болон пейжүүддээ байршуулж ажиллалаа.. Төрийн албан хаагчийн ХАСХОМ гаргах албан хаагчдыг хуулийн хугацаанд мэдүүлэх ажлыг мөн зохион байгуулсан.	100%
3.1.14.	Иргэдээс өргөдөл, гомдлыг шийдвэрлэж ажиллана.	-	Шийдвэрлэлтийн хувь	100	100	2025 оны 11 дүгээр сарын 28-ны байдлаар 1 өргөдөл гомдол ирснийг 100 хувь шийдвэрлэсэн.	100%
3.1.15.	Дүүргийн биеийн тамир, спортын байгууллага, хамтрагч байгууллага, хамтлаг, арга зүйчдийг шалгаруулж урамшуулна.	Улсын төсөв: 3,000.0	Болзлын дагуу шилдгүүдийг шалгаруулсан тоо	15	16	Баянзүрх дүүргийн 2025 оны Баянзүрх дүүргийн шилдэг багш дасгалжуулагч, сурагч тамирчин, арга зүйч, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хороо, аж ахуй нэгж гэх мэт 15 номинацийн дагуу шилдгүүдийг шалгаруулж, өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.	100%

3.1.16.	Хүний нөөцийн сургалт, хөгжүүлэлтийн төлөвлөгөө биелэлтийг хангаж ажиллана.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	0	100	Нийслэлийн Засаг даргын тамгын газрын төрийн захиргаа удирдлагын газрын хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс сар бүр төлөвлөгөө илгээн, ирсэн төлөвлөгөөний дагуу ажилчдаас асуулга явуулж сургалтуудад сар бүр тогтмол хамрагдаж байна. 2025 оны 01 дүгээр сарын 02-ноос 11 дүгээр сарын 28-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулагдсан 30 удаагийн цахим болон танхимын сургалт, 22 удаагийн уулзалт, арга хэмжээнд 14 албан хаагчдыг идэвхтэй хамруулсан байна. Мөн 5 албан хаагч төрийн өмчийн их сургуульд суралцаж, мэдлэг чадвараа дээшлүүлэхэд байгууллагын зүгээс дэмжин ажиллаж байна.	100%
Хэсгийн дундаж							
Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хороо нь 2025 онд 3 зорилтыг хэрэгжүүлэх 50 ажил төлөвлөсөн бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 28-ний байдлаар 3 зорилт, 50 арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж 94,39 хувьтай биеийн тамир, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээнд улсын төсвөөс 73,064,600 төгрөг, орон нутгийн төсвөөс 321,680,000 төгрөг зарцуулсан байна.							

(Хүснэгт-2)

Зорилт тус бүрийн хэрэгжилтийн үр дүн:

№	Зорилтын нэр	Арга хэмжээний тоо	Зорилтын дундаж хувь
1.	Биеийн тамир, спортын үйлчилгээг өргөжүүлж, биеийн тамир, спортыг хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг болгох таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	21	88,57%
2.	Орчин үеийн шаардлага, олон улсын жишиг, иргэдийн эрэлт хэрэгцээ, үндэсний онцлогт нийцсэн биеийн тамир, спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх, дүүрэгт үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын залгамж халааг бэлтгэх, тэмцээн уралдаанд оролцож амжилтаа ахиулах таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	13	94,61%

3.	Төрийн байгууллагын нийтлэг чиг үүргийг ханган ажиллана.	16	100%
	Зорилтын дундаж	50	94,39%

Үр дүн: Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 94,39 хувьтай буюу “бүрэн хангалттай” гэж үнэллээ.

ТАНИЛЦСАН:

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА

ХЯНАСАН:

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АСУУДАЛД ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.БАТХҮҮ

Э.БАТХҮҮ

Б.МӨНХЗАЯА